



МОНГОЛ АЛТ ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 04-ны өдөр

№ 04

Дархан-Уул аймаг

Өрийн бичиг гаргах, их хэмжээний
хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компаний тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2, 41.3, 41.4 дэх заалт, "Монгол-Алт" ХК-ийн дүрмийн 9.6 дугаар зүйлийн 9.6.2, 9.6.22 дахь заалт, 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын 04 тоот тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ-ийн биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам болон бусад хууль тогтоомжийн хүрээнд "Монгол-Алт" ХК-ийн барьж байгаа "Дарханы Дулааны Сүлжээ" ТӨХК-ийн 108 айлын орон сууцны барилгын төслийг хэрэгжүүлэх зорилгоор биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд бондын хөтөлбөр хэлбэрээр дараах нөхцөлтэйгөөр өрийн хэрэгсэл гаргахыг зөвшөөрсүгэй. Үүнд:

1	Өрийн хэрэгслийн нэр	ERS бонд
2	Өрийн хэрэгслийн нийт дүн	6,000,000,000 төгрөг,
3	Өрийн хэрэгслийн нэгжийн үнэ	1,000,000 төгрөг,
4	Өрийн хэрэгслийн хугацаа	12 сар,
5	Жилийн хүү	21.0%,
6	Хүү төлөх давтамж	Улирал тутам,
7	Үүргийн гүйцэтгэл хангах арга	1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан "Монгол-Алт" ХК-ийн эзэмшилд буй үл хөдлөх хөрөнгүүд, эзэмших эрхтэй газрын хамт.

2. Биржийн бус зах зээлд гаргах өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор "Монгол-Алт" ХК-ийн эзэмшилд буй нийт **11,520,020,000.0** төгрөгийн үнэлгээ бүхий Хавсралт №1-д дурдсан үл хөдлөх хөрөнгүүд, эзэмших эрхтэй газруудыг андеррайтерт барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.

3. Биржийн бус зах зээлд гаргах өрийн хэрэгслийн андеррайтераар "Тэнгэр Капитал ҮЦК" ХХК-ийг сонгохоор шийдвэрлэж, холбогдох гэрээний нөхцөлийг тохирох болон андеррайтераас шаардсан бусад холбогдох гэрээ хэлцэл байгуулах, энэхүү шийдвэрийн 2-т заасан барьцаа хөрөнгийг барьцаалахтай холбоотой барьцааны гэрээнд "Монгол-Алт" ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг "Монгол-Алт" ХК-ийн Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д олгосугай.

4. Өрийн хэрэгслийн гэрээний хэрэгжилт, өрийн хэрэгслийн хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлт, өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой гарсан зардлыг тухай бүрд төлж барагдуулах, холбогдох гэрээний үүргээ биелүүлж ажиллахтай холбоотой үйл


ажиллагааг удирдан зохион байгуулах, өрийн хэрэгслийн хүрээнд их хэмжээний хэлцэл хийх эрхийг "Монгол-Алт" ХК-ийн Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д олгосугай.

5. Энэхүү шийдвэрийн дагуу холбогдох мэдээллийг тогтоосон журмын дагуу олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (С.Бат-Эрдэнэ)-д, шаардлагатай зөвшөөрлийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.4-д заасны дагуу авахыг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д тус тус даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



ЛАМАРСАНАА



БАРЬЦААЛАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Барьцаа хөрөнгийн төрөл	Өмчлөгч	Зориулалт	Улсын бүртгэлийн дугаар	Гэрчилгээний дугаар	Хэмжээ /м.кв/	Хаяг	Барьцаа хөрөнгийн үнэлгээ /төгрөгөөр/	Тайлбар
1	Барилга	"Монгол алт" ХК	Агуулах	Ү-2003005936		465	Дархан-Уул аймгийн Дархан сумын 7-р баг, Хуульчид-3, 301Б тоот	122,170,000	"Голомт Капитал ҮЦК" ХХК болон "Монгол-Алт" ХК нарын 2023 оны 5-р сарын 31-ний өдрийн 23/52 тоот Барьцааны гэрээний дагуу "Монголын финтек групп" ХК-ийн биржийн бус зах зээлд гаргасан бондын үүргийн гүйцэтгэлд барьцаалагдсан.
2	Эзэмших эрхтэй газар	"Монгол алт" ХК	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	4506503713 Э-2003003455	№0000052095	8,544	Дархан-Уул аймгийн Дархан сумын 7-р баг, Хуульчид-3, 301Б тоот	1,089,350,000	
3	Барилга	"Монгол алт" ХК	Контор үйлчилгээний зориулалттай	Ү-2003005934		3,263	Дархан-Уул аймгийн Дархан сумын 7-р баг, Хуульчид-3, 301 тоот	4,701,300,000	
4	Эзэмших эрхтэй газар	"Монгол алт" ХК	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	4506503712 Э-2003003453		7,037	Дархан-Уул аймгийн Дархан сумын 7-р баг, Хуульчид-3, 301 тоот		
5	Барилга	"Монгол алт" ХК	Цехийн барилга	Ү-2003005939		1,080	Дархан-Уул аймгийн Дархан сумын 7-р баг, Хуульчид-3, 301А тоот	1,556,100,000	
6	Эзэмших эрхтэй газар	"Монгол алт" ХК	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	4506503711 Э-2003003454	№0000052064	2,506	Дархан-Уул аймгийн Дархан сумын 7-р баг, Хуульчид-3, 301А тоот		
7	Барилга	"Монгол алт" ХК	Үйлчилгээний зориулалттай "Шинэ Орчин" худалдаа үйлчилгээний төв	Ү-2003020623		2,812	Дархан-Уул аймгийн Дархан сумын 7-р баг	4,051,100,000	Барьцаалагдаагүй.
Нийт дүн								11,520,020,000	